



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Төвшрүүлэх сумын ЭМТ-ийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** АРА-2026/079/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mnp](http://www.audit.mnp)  
Эрдэнэбулган хот  
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Т.Байгалмаа  
Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn  
Аудитын менежер: Д.Нэргүйбаатар  
Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatar@audit.gov.mn  
Цахим актив аудит ХХК: Аудитор: Д.Эрдэнэцэцэг  
Утас: 99019943 Цахим хаяг: tsakhimactive@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,  
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,  
Утас/Факс: (976) 7033 3141,  
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2026.02.25 № 13д  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ТӨВШРҮҮЛЭХ СУМЫН ЭРҮҮЛ  
МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА  
Л.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Төвшрүүлэх сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тус байгууллага нь Эрүүл мэндийн даатгалын хэлтэстэй байгуулсан гэрээний дагуу 4160 хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлж, Эрүүл мэндийн даатгалын сангаас иргэдэд үзүүлсэн эмнэлгийн тусламж үйлчилгээний 69,142.8 мянган төгрөгийн санхүүжилтийн авлага бүртгэж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.

**Аудитын гол асуудал**

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,079,259.7 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 1,020,910.9 мянган төгрөгийг зарцуулан 58,348.8 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Тайлант онд урсгал зардлаас 14,610.5 мянган төгрөгийн, Эрүүл мэндийн яам болон бусад байгууллагын хандив тусламжаар 41,180.8 мянган төгрөгийн нийт 59,290.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 16,523.3 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, бусад хангамжийн материал үнэ төлбөргүй хүлээн авч, данс бүртгэлд тусгасан байна

### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилт 56 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дээд шатны төсөв захирагчаас 87.8 хувийн гүйцэтгэлтэй гэж дүгнэсэн байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ****2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>205,945,088.66</b>	<b>227,000,537.33</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	7,807,193.98	58,348,857.71
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	7,807,193.98	58,348,857.71
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	7,807,193.98	58,348,857.71
31211	Төрийн сангийн харилцах	7,807,193.98	58,348,857.71
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	95,314,730.37	69,142,828.87
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	95,314,730.37	69,142,828.87
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	102,823,164.31	99,508,850.75
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	64,451,292.73	61,222,319.67
35110	Тусгай зориулалттай материал	26,327,112.80	26,486,377.65
35130	Эм боох материал	38,124,179.93	34,735,942.02
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	38,371,871.58	38,286,531.08
35410	Бичиг хэргийн материал	696,502.73	696,502.73
35420	Аж ахуйн материал	32,816,704.85	26,606,161.35
35430	Сэлбэг хэрэгсэл	2,086,000.00	3,486,000.00
35440	Түлш, шатах тослох материал	1,380,000.00	2,650,000.00
35450	Барилгын засварын материал	-	1,934,500.00
35460	Хүнсний материал	1,392,664.00	2,913,367.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,055,892,637.50</b>	<b>1,030,092,324.11</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,055,892,637.50	1,030,092,324.11
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,042,026,070.99	1,016,253,624.08
39201	Барилга, байгууламж, орон сууц	964,925,476.49	964,925,476.49
39202	Хуримтлагдсан элэгдэл	(103,462,660.86)	(121,746,427.14)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	94,016,833.00	94,016,833.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(61,645,839.68)	(74,858,840.10)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	226,754,725.01	281,534,705.01
39206	Хуримтлагдсан элэгдэл	(108,567,686.53)	(160,408,846.71)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	7,575,000.00	12,085,500.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(2,972,500.05)	(4,697,500.08)
39214	Бусад үндсэн хөрөнгө	19,208,668.00	19,208,668.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(19,147,981.39)	(19,147,981.39)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	25,342,037.00	25,342,037.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	13,866,566.51	13,838,700.03
39301	Програм хангамж	418,000.00	418,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(327,433.49)	(355,299.97)
39303	Бусад биет бус хөрөнгө	13,776,000.00	13,776,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,261,837,726.16</b>	<b>1,257,092,861.44</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b>1,171,600.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	1,171,600.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	-	1,171,600.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	-	1,171,600.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	1,171,600.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,261,837,726.16</b>	<b>1,255,921,261.44</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,261,837,726.16	1,255,921,261.44
511	Засгийн газрын оруулсан капитал /	279,444,472.38	279,444,472.38
51101	Өмч: - төрийн	279,444,472.38	279,444,472.38
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	188,611,352.27	182,694,887.55

51210	Өмнөх үеийн үр дүн	188,611,352.27	188,611,352.27
51220	Тайлант үеийн үр дүн	-	(5,916,464.72)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	793,781,901.51	793,781,901.51
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,261,837,726.16</b>	<b>1,257,092,861.44</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>929,504,743.07</b>	<b>1,046,626,159.72</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,500,000.00</b>	<b>85,207,322.62</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	3,500,000.00	85,207,322.62
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,500,000.00	68,683,987.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,500,000.00	24,004,007.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого ҮХ		44,679,980.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого БМ		16,523,335.62
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>926,004,743.07</b>	<b>961,418,837.10</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	40,007,400.00	48,961,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	40,007,400.00	48,961,700.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	885,997,343.07	912,457,137.10
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	885,997,343.07	912,457,137.10
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>919,733,200.20</b>	<b>1,052,542,623.99</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>919,733,200.20</b>	<b>1,052,542,623.99</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	917,339,982.20	1,042,968,805.99
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	573,884,271.00	678,572,077.00
210101	Үндсэн цалин	366,816,585.00	389,648,662.00
210102	Нэмэгдэл	168,994,304.00	239,330,493.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	5,495,396.00
210104	Урамшуулал	38,073,382.00	44,097,526.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	74,926,767.02	87,177,189.87
210201	Тэтгэврийн даатгал	55,422,667.02	59,282,043.47
210202	Тэтгэмжийн даатгал	4,876,000.00	6,986,345.38
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,438,000.00	4,407,949.65
210204	Ажилгүйдлийн даатгал	2,438,000.00	3,296,910.16
210205	Эрүүл мэндийн даатгал	9,752,100.00	13,203,941.21
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	31,994,985.00	33,117,882.00
210301	Гэрэл, цахилгаан	4,961,682.00	5,318,382.00
210302	Түлш, халаалт	26,983,303.00	27,749,500.00
210303	Цэвэр, бохир ус	50,000.00	50,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	40,678,830.80	45,260,035.50
210401	Бичиг хэрэг	6,320,840.00	5,148,500.00
210402	Тээвэр, шатахуун	16,873,721.00	14,455,352.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,544,289.80	4,877,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,906,000.00	2,233,150.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,033,980.00	18,545,433.50
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	100,829,104.96	86,292,414.02
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	88,285,140.96	72,758,682.47
210502	Хоол, хүнс	11,137,964.00	10,308,732.00

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,406,000.00	3,225,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>8,222,850.00</b>	<b>11,951,864.21</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	947,350.00	2,818,864.21
210604	Урсгал засвар	7,275,500.00	9,133,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>3,129,000.00</b>	<b>5,420,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	3,129,000.00	5,420,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,334,000.00</b>	<b>3,253,100.00</b>
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,024,000.00	1,368,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	310,000.00	1,885,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>82,340,173.42</b>	<b>91,924,243.39</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,443,700.00	6,833,450.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	76,896,473.42	85,090,793.39
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,393,218.00</b>	<b>9,573,818.00</b>
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>2,393,218.00</b>	<b>9,573,818.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,393,218.00	9,573,818.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>9,771,542.87</b>	<b>(5,916,464.72)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>9,771,542.87</b>	<b>(5,916,464.72)</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>848,583,421.70</b>	<b>1,011,594,745.60</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,500,000.00</b>	<b>24,004,007.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>3,500,000.00</b>	<b>24,004,007.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,500,000.00	24,004,007.00
1E+06	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,500,000.00	24,004,007.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>845,083,421.70</b>	<b>987,590,738.60</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>40,007,400.00</b>	<b>48,961,700.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	40,007,400.00	48,961,700.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>805,076,021.70</b>	<b>938,629,038.60</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	805,076,021.70	938,629,038.60
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>839,032,944.82</b>	<b>946,442,581.87</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>839,032,944.82</b>	<b>946,442,581.87</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>836,639,726.82</b>	<b>936,868,763.87</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>573,884,271.00</b>	<b>678,572,077.00</b>
210101	Үндсэн цалин	366,816,585.00	380,945,802.00
210102	Нэмэгдэл	168,994,304.00	248,270,144.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	5,495,396.00
210104	Урамшуулал	38,073,382.00	43,860,735.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>74,926,767.02</b>	<b>87,177,189.87</b>
210201	Тэтгэврийн даатгал	55,422,667.02	60,054,807.70
210202	Тэтгэмжийн даатгал	4,876,000.00	6,783,579.76
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,438,000.00	3,343,078.30
210204	Ажилгүйдлийн даатгал	2,438,000.00	3,333,918.10
210205	Эрүүл мэндийн даатгал	9,752,100.00	13,661,806.01
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>32,621,182.00</b>	<b>34,387,882.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	4,961,682.00	5,318,382.00
210302	Түлш, халаалт	27,609,500.00	29,019,500.00

210303	Цэвэр, бохир ус	50,000.00	50,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>45,141,330.80</b>	<b>40,452,042.00</b>
210401	Бичиг хэрэг	6,455,840.00	4,918,500.00
210402	Тээвэр, шатахуун	16,645,721.00	14,349,752.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,544,289.80	4,877,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,406,000.00	2,233,150.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,089,480.00	14,073,040.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>84,205,626.00</b>	<b>66,155,603.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	69,530,280.00	53,134,168.00
210502	Хоол, хүнс	11,849,346.00	11,396,435.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,826,000.00	1,625,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>15,953,850.00</b>	<b>14,617,420.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,497,350.00	2,149,920.00
210604	Урсгал засвар	8,456,500.00	12,467,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>3,129,000.00</b>	<b>5,420,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	3,129,000.00	5,420,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,334,000.00</b>	<b>3,253,100.00</b>
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,024,000.00	1,368,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	310,000.00	1,885,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>5,443,700.00</b>	<b>6,833,450.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,443,700.00	6,833,450.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,393,218.00</b>	<b>9,573,818.00</b>
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>2,393,218.00</b>	<b>9,573,818.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,393,218.00	9,573,818.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>9,550,476.88</b>	<b>65,152,163.73</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>11,799,900.00</b>	<b>14,610,500.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>11,799,900.00</b>	<b>14,610,500.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>11,799,900.00</b>	<b>14,610,500.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	11,799,900.00	14,610,500.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(11,799,900.00)</b>	<b>(14,610,500.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>(2,249,423.12)</b>	<b>50,541,663.73</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>7,807,193.98</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>7,807,193.98</b>	<b>58,348,857.71</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
-----	----------	---------------------------------	-----------------------	-------------------	---

C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	279,444,472.38	793,781,901.51	188,611,352.27	1,261,837,726.16
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	279,444,472.38	793,781,901.51	188,611,352.27	1,261,837,726.16
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	279,444,472.38	793,781,901.51	188,611,352.27	1,261,837,726.16
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(5,916,464.72)	(5,916,464.72)
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	279,444,472.38	793,781,901.51	182,694,887.55	1,255,921,261.44

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,166,497,100	951,479,264
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,166,497,100	951,479,264
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,112,415,100	951,479,264
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	737,717,900	678,572,077
210101	Үндсэн цалин	477,327,500	380,945,802
210102	Нэмэгдэл	174,915,900	248,270,144
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,836,000	5,495,396
210104	Урамшуулал	77,638,500	43,860,735
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	90,964,900	87,177,190
210201	Тэтгэврийн даатгал	61,856,100	60,054,808
210202	Тэтгэмжийн даатгал	7,277,200	6,783,580
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,638,600	3,343,078
210204	Ажилгүйдлийн даатгал	3,638,600	3,333,918
210205	Эрүүл мэндийн даатгал	14,554,400	13,661,806
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	43,961,700	34,387,882
210301	Гэрэл, цахилгаан	10,711,700	5,318,382
210302	Түлш, халаалт	33,000,000	29,019,500
210303	Цэвэр, бохир ус	250,000	50,000
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	47,544,700	39,552,042
210401	Бичиг хэрэг	5,601,400	4,918,500
210402	Тээвэр, шатахуун	18,600,000	14,349,752
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,387,400	4,877,600
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,455,900	2,233,150
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,500,000	13,173,040
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	121,850,900	66,155,603
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	98,457,900	53,134,168
210502	Хоол, хүнс	16,493,000	11,396,435

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,900,000	1,625,000
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	42,250,000	30,127,920
210601	Багаж, техник, хэрэгсэл	15,500,000	13,149,920
210602	Тавилга	20,000,000	4,510,500
210604	Урсгал засвар	6,750,000	12,467,500
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	13,800,000	5,420,000
210702	Дотоод албан томилолт	8,800,000	5,420,000
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	3,850,000	3,253,100
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,450,000	1,368,100
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,000,000	1,885,000
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	10,475,000	6,833,450
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,475,000	6,833,450
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,152,225,407	1,002,020,928
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	48,961,700	39,387,882
132001	Орон нутгийн төсвөөс	48,961,700	39,387,882
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,079,259,700	938,629,038.60
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,079,259,700	938,629,039
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	24,004,007	24,004,007
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	24,004,007	24,004,007
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		7,807,193.98
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		58,348,857.71
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	24	24
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	18	18
620003	Үйлчлэх ажилтан	5	5

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа<sup>1</sup> илрээгүй.

Аудитаар залруулагдаагүй 4,660.0 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрсэнд 1 төлбөрийн акт тогтоож, 1 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлээ.

Аудитаар залруулагдаагүй материаллаг алдааны зөрчил нь 4,660.0 мянган төгрөг бөгөөд тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 10,618.3 мянган төгрөгөөс бага байгаа тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

5.1.1 Орон нутгаас олгож буй байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын зарцуулагдаагүй үлдэгдлийг татан төвлөрүүлээгүй, эдийн засгийн ангилал зөрчин, байгууллагын үндсэн үйл

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

ажиллагааны зардал болох авто машины сэлбэг, аж ахуйн материал худалдан авч төсвийг зориулалт бусаар зарцуулсан 1,657.0 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 45 дугаар зүйлийн 45.2-д “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, Сангийн сайдын 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 112 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт “Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал”, хоёрдугаар хавсралт “Зардлын эдийн засгийн ангилалын тайлбар”-т Хэрэглүүрийн гуравт “Төсөв боловсруулж батлуулах, гүйцэтгэлийн тайлан гаргах, зардлын хяналт, аудит хийхэд ашиглана”, Төсвийн захирагчийн үүрэгт “Зардлын ангилалын тодорхойлолтод заасны дагуу нийцүүлж зөв бүртгэх, мэдээлэх, тайлагнах үүргийг төсвийн бүх шатны захирагчид хүлээнэ”, 2103 -д” байр ашиглалттай холбоотой тогтмол зардалын тодорхойлолт”, гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо

## 5.2 Албан шаардлага

5.1.1 Ерөнхий гэрээний худалдан авалтаар нийлүүлэгдэх эм, эмнэлгийн хэрэгслийг төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрээс худалдан аваагүйтэй холбоотой 3,003.0 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31.2-т “Энэ хуулийн 37.2.4-т тодорхойлсон захиалагч ерөнхий гэрээ байгуулсан бараа, үйлчилгээг энэ хуульд өөрөөр заагаагүй бол цахим дэлгүүрээс худалдан авна”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14.4-д “Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно”, Эм эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын 2025 оны 01/103 албан тоотын заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүллээ.

5.1.2 Тайлант онд аймгийн Эрүүл мэндийн газраас зарласан “Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл” нийлүүлэх ААЭМГ/20250102001 дугаартай тендерийн гэрээний хэрэгжилт хангагдаагүй, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйтэй холбоотой алдаа зөрчил илэрлээ.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 32.1-д “Энэ хуульд өөрөөр заагаагүй бол захиалагч бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад нээлттэй тендер шалгаруулалтын аргыг хэрэглэнэ.”, ААЭМГ/20250102001 дугаартай тендерийн гэрээний заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүллээ

## 5.3 Зөвлөмж

5.3.1. Санхүүгийн программд 2014 онд бүртгэсэн үндсэн хөрөнгийн ашиглах жил оруулаагүйтэй холбоотой 1 нэр төрлийн 25,3 сая төгрөгийн хөрөнгөд элэгдэл тооцоогүй зөрчил илэрлээ.

Энэ нь Сангийн сайдын 2025 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалын хавсралтын 10 дугаар зүйлийн 10.24-д “Үндсэн хөрөнгийг ашиглахад бэлэн болсон үеэс эхлэн элэгдүүлнэ”, 10.26--д “Хөрөнгийн үлдэх өртөг, ашиглахаар тооцсон үлдсэн хугацаа, элэгдлийн аргыг санхүүгийн жил бүрийн эцэст хянаж, тооцооллын өөрчлөлтийг гүйцээх горимоор бүртгэнэ” гэсэнтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дараа тайлангийн хугацаанд тухайн хөрөнгийн элэгдлийг нөхөн тооцож, холбогдох дансдад бүртгэж зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллах.

Дээрх төлбөрийн акт, зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасны дагуу шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 05 дүгээр сарын 20-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Архангай аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 06 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Ерөнхий гэрээний худалдан авалтаар нийлүүлэгдэх эм, эмнэлгийн хэрэгслийг төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрээс худалдан аваагүй		3,003.0				3,003.0		
Тайлант онд аймгийн Эрүүл мэндийн газраас зарласан "Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл"нийлүүлэх ААЭМГ/20250102001 дугаартай тендерийн гэрээний хэрэгжилт хангагдаагүй, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй,	1	0.00			1	0.00		
Орон нутгаас олгож буй байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг зориулалт бусаар зарцуулсан	1	1,657.00	1	1,657.00				
Санхүүгийн программд ашиглалтад орсон огноо, ашиглах жил оруулаагүйтэй холбоотой 1 нэр төрлийн 25.3 сая төгрөгийн хөрөнгөд элэгдэл тооцоогүй,	1	0.00					1	0
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>4,660.0</b>	<b>1</b>	<b>1657.0</b>	<b>1</b>	<b>3,003.0</b>	<b>1</b>	<b>-</b>